



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 01

Хэрлэн сум

Г Зөвшөөрөл олгох тухай Г

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 80 дугаар зүйлийн 80.2, 87 дугаар зүйлийн 87.1.1, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.3.16 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн а/321 тоот албан бичгээр ирүүлсэн удирдамж, Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр ирүүлсэн 8/26 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан “Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх” төслийн хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, бараа материал хил, гааль дээр саатаж барилга угсралтын ажлыг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон тул Монгол Улсын Хөгжлийн банк, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн хооронд 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан “ЗГ-ДБ-3 2021-17” дугаартай зээлийн гэрээ болон эргэн төлөлтийн хуваарьт холбогдох хууль, журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт зөвшөөрсүгэй.

2. Хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ЖАНАРБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ  
ЗӨВЛӨЛ  
ТТР0374 - 2628051  
ДОРНОД АЙМАГ